



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
УЛСЫН БҮРТГЭЛ, СТАТИСТИКИЙН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2016 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/02

Сүмбэр сум

Комисс томилж, журам батлах тухай

Архивын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 06 дугаар сарын 7-ны өдрийн 59 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын ажлын үндсэн заавар”-ын 2.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын бүртгэл статистикийн газрын дэргэдэх баримт бичиг нягтлан шалгах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр баталсугай.

КОМИССЫН ДАРГА:	Бүртгэлийн хэлтсийн дарга
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:	Бичиг хэрэг
ГИШҮҮД:	Бүртгэлийн хэлтсийн ЭХЭБ-ийн улсын ахлах бүртгэгч Статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Нягтлан бодогч

2. Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Баримт бичиг нягтлан шалгах комиссын дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллахыг комисст үүрэг болгосугай.

4. Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/10, Статистикийн хэлтсийн даргын 2015 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/02 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ЦЭЛМЭГ